**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 09 сарын 01 өдөр Дугаар А/52 Улаанбаатар хот

Стандартын хэрэгжилтэд
хяналт, үнэлгээ хийх тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйл, Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын 9.2 заалт, Төвийн "Дотоод аудит зохион байгуулах" журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Менежментийн тогтолцооны ISO 9001:2015, ISO 45001:2018 стандартын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, үнэлгээ хийх төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Стандартын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх нөхцөлийг бүрдүүлэн, хамтран ажиллахыг алба, тасгийн дарга, эрхлэгч нарт, үнэлгээний дүн, тайланг төвийн Удирдлагын зөвлөлд 2025 оны 09 сарын 12-ны дотор танилцуулан, зохих арга хэмжээ авч ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Э.Тунгалагтуяа)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны дарга (Л.Энхчимэг)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ Б.НАРАНТУЯА

1118266548 ☎9128905

ЦССҮТ-ийн захирлын 2025 оны
09 дүгээр сарын 01-ний өдрийн
А/152 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ УДИРДАМЖ

**Зорилго:**

Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тогтолцоо MNS ISO 45001:2018 стандартын дагуу үр нөлөөтэй хэрэгжиж байгааг үнэлэх, дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Зорилт:**

1. Стандартын шаардлагын дагуу үнэлгээ хийх
2. Үнэлгээний дүнд үндэслэн зөвлөмж, сайжруулах саналыг хүргүүлэх

**Хамрах хүрээ:**

ЦССҮТ-ийн алба, тасгууд

**Үнэлгээний баг:**

Захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг

**Хугацаа:**

2025.09.02-2025.09.05

**Үр дүн:**

Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тогтолцоо MNS ISO 45001:2018 стандартын шаардлагад нийцэж буйг болон цаашид сайжруулах саналыг тодорхойлон стандартын хэрэгжилтийн тасралтгүй байдлыг хангана.

ЦССҮТ-ийн захирлын 2025 оны
09..дүгээр сарын..01..-ний өдрийн
А/132..дугаар тушаалын
2 дугаар хавсралт

**Ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

| | | |
|---|---|---|
| Ахлагч: | Э.Тунгалагтуяа | Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга |
| Гишүүд: | М.Цэрэндэжид | Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч |
| | Ж.Нармандах | Сувилахуй, үйлчилгээний албаны дарга |

ЦССҮТ-ийн захирлын 2025 оны
09 дүгээр сарын 01-ний өдрийн
1152 дугаар тушаалын
3 дугаар хавсралт

1118266548 9128905

## Хяналт, үнэлгээ хийх төлөвлөгөө

| № | Үйл ажиллагаа | Хугацаа /Сар, өдөр/ | Хариуцах эзэн | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|
| 1: | Хяналт үнэлгээ, хийх мэдээллийг алба, тасгуудад хүргүүлнэ. | 2025.09.01 | Э.Тунгалагтуяа | Хяналт, үнэлгээ хийх мэдээллийг ажиллагсад хүлээн авч, бэлэн байдлыг хангасан байна. |
| 2 | Хяналт үнэлгээний ажлын хэсгийн ахлагч, гишүүдийг сонгож үндэсний төвийн захирлын тушаал гаргах | 2025.09.01 | Э.Тунгалагтуяа | Хяналт, үнэлгээ хийх багийг томилсон захирлын тушаал гарсан байна. |
| 3 | Ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд аудит явуулах чиглэл өгөх | 2025.09.01 | Э.Тунгалагтуяа | Хяналт, үнэлгээний үйл ажиллагаа төвийн Дотоод аудитын журмын дагуу зохион байгуулагдсан байна. |
| 4 | Хяналт, үнэлгээг зохион байгуулах | 2025.09.02-2025.09.05 | Багийн гишүүд | |
| 5 | Хяналт үнэл үнэлгээний тайлан бичих | 2025.09.08 | Багийн гишүүд | Хяналт үнэлгээний тайлан, зөвлөмж гарч үнэлгээнд хамрагдсан ажиллагсдад танилцуулагдсан байна. |
| 6 | Хаалтын хурал | 2025.09.08 | Багийн гишүүд | |
| 7 | Үл тохирол хаах, сайжруулах санал зөвлөмжийн хэрэгжилтийг хангах | 2025.11.01 | Холбогдох алба, тасаг | Гарсан үл тохирлыг арилгаж, сайжруулах санал зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. |

---oOo---